

**Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан  
зардлыг нөхөн төлөх тухай  
ГЭРЭЭ**

2016 оны 11 дугаар  
сарын 10-ны өдөр

дугаар ХАЗ-2016.1.10.

Улаанбаатар  
хот

**Ерөнхий зүйл**

Нэг талаас Ашигт малтмал, Газрын тосны газар, нөгөө талаас ашигт малтмалын ордын MV-000926, MV-009305 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшигч Улсын бүртгэлийн албанд бүртгэлтэй 1411007090 тоот гэрчилгээ, 2819996 тоот регистрийн дугаартай “Уулс заамар” ХХК /цаашид аж ахуйн нэгж/ нь Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйл, Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн дугаар 81 тоот тогтоолоор батлагдсан журмыг үндэслэн улсын төсвийн хөрөнгөөр хийсэн Төв аймгийн Заамар сумын нутаг дахь Заамарын эх, Дунд галт орд дээр хийгдсэн эрэл-зураглал, эрэл-үнэлгээ, нарийвчилсан хайгуулын ажлын зардлуудыг улсын төсөвт эргүүлэн нөхөн төлөх нөхцөл, үе шат, төлбөрийн хэмжээ, хүлээх хариуцлагыг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

**Нэгдүгээр зүйл. Ерөнхий эрэл, урьдчилсан хайгуул, нарийвчилсан хайгуул,  
гидрогеологийн хайгуул, зураглалын ажлын зардлын нийт хэмжээ**

Төв аймгийн Заамар сумын нутаг дахь Заамарын эх орд дээр байрлах MV-000926, Төв аймгийн Заамар сумын нутаг дахь Дунд галт орд дээр байрлах MV-009305 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн талбайд 1971-1994 онуудад улсын төсвөөс нийтдээ 691,008,63 (зургаан зуун ерэн нэгэн мянга найман төгрөг жаран гурван мөнгө) төгрөгийн зардал гарсан бөгөөд ноогдох хэмжээг үндэслэн Засгийн газрын 2007 оны 81 дүгээр тогтоолоор баталсан журамд заасан аргачлалын дагуу тооцоход 516,950,037.67 (таван зуун арван зургаан сая, есөн зуун тавин мянга, гучин долоон төгрөг жаран долоон мөнгө) төгрөгөөр тооцож байгааг хоёр тал хүлээн зөвшөөрөв.

**Хоёрдугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх,  
хүлээх үүрэг, хариуцлага**

2. 1. Энэхүү гэрээний нэгдүгээр зүйлд заасан зардлыг 5 жилийн хугацаанд гэрээний хавсралт №1-д заасан хуваарийн дагуу төлнө.

2016 онд 34,000,000 төгрөг / гучин дөрвөн сая / төгрөг  
(тоогоор) (үсгээр)

2017 онд 139,000,000 төгрөг / нэг зуун гучин есөн сая / төгрөг  
(тоогоор) (үсгээр)

2018 онд 139,000,000 төгрөг / нэг зуун гучин есөн сая / төгрөг  
(тоогоор) (үсгээр)

№ХАЗ- 20.1.16.1.10 гэрээ

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

2019 онд 104,000,000 төгрөг / нэг зуун дөрвөн сая / төгрөг  
(тоогоор) (үсгээр)

2020 онд 100,950,037.67 төгрөг / нэг зуун сая есөн зуун тавин мянга гучин  
долоон төгрөг жаран долоон мөнгө / төгрөг  
(тоогоор) (үсгээр)

2.2 Энэхүү гэрээний 2 дугаар зүйлийн 2.1-г дурьдсан хугацаанд хийхээр хуваарилсан төлбөрийг тухайн онд хавсралт 1-д заасан байдлаар Төрийн сан банкны төгрөгийн 900000712 Ашигт малтмал, газрын тосны газрын дансанд хийнэ.

2.3 Хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөр хийсний дараа уг төлбөр Ашигт малтмал, газрын тосны газрын дансанд орсон эсэхийг шалгаж болно.

2.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээний 2 дугаар зүйлийн 2, 3-аар тохиролцсон үүргийн дагуу тухайн улирлын төлбөрөө улиралдаа багтаан хийгээгүй бол Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 7 дахь заалтын дагуу хугацаа хэтэрсэн хоног тутам тухайн улиралд төлбөл зохих төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алданги төлнө.

2.5 Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан нөхөн төлбөр, алдангийг төлөөгүй бол тусгай зөвшөөрлийг цуцалж, тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайд сонгон шалгаруулалт зарлана.

### **Гурав дугаар зүйл. Ашигт малтмал, газрын тосны газрын эрх, хүлээх үүрэг, хариуцлага**

3.1 Энэхүү гэрээний нэгдүгээр зүйлд заасан нөхөн төлбөрийн хэмжээг нөхөн төлбөр хийхээр тохиролцсон хугацаанд өөрийн санаачилгаараа өөрчлөхгүй.

3.2 Нөхөн төлбөр хийсэн хугацааг банкинд гүйлгээ хийсэн өдрөөр тооцно.

3.3 Аж ахуйн нэгж гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд хууль, АМГТГ нь гэрээнд заасны дагуу шаардах эрхтэй.

3.5 а. Ашигт малтмалын ордын нарийвчилсан эрэл, эрэл-үнэлгээний ажлын тухайн талбайд ногдох зардал, хайгуулын бүх шатны ажилд улсын төсвөөс гаргасан нөхөн төлбөрийн төлөх хугацааг ТЭЗҮ, уулын ажлын тайлан болон төлөвлөгөөнд тулгуурлан АМГТГ-ын Уул уурхайн үйлдвэрлэл технологийн хэлтэс,

б. Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардалд ашигт малтмалын ордын нарийвчилсан эрэл, эрэл-үнэлгээний ажлын тухайн талбайд ногдох зардал, хайгуулын бүх шатны ажилд улсын төсвөөс гаргасан нөхөн төлбөрийн тооцооллыг АМГТГ-ын Геологи хайгуулын хэлтэс

с. Ашигт малтмалын ордын нарийвчилсан эрэл, эрэл-үнэлгээний ажлын тухайн талбайд ногдох зардал, хайгуулын бүх шатны ажилд улсын төсвөөс гаргасан нөхөн төлбөрийн хуваарь гаргах, гэрээ боловсруулах, хэрэгжилтэнд хяналт тавихыг Хууль, эрх зүйн хэлтэс тус тус хариуцана.

3.6 Нөхөн төлбөрийн төлөлттэй холбоотой асуудлыг гэрээ байгуулсан аж ахуйн нэгж бүрэн хариуцана.

**Дөрөв дүгээр зүйл. Гэрээ хүчин төгөлдөр болох, гэрээний хугацаа, бусад**

4.1. Энэхүү гэрээ нь Ашигт малтмал, газрын тосны газар болон аж ахуйн нэгжийг төлөөлөх эрх бүхий этгээд /захирал/ гэрээнд гарын үсэг зурж тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

4.2 Гэрээний нийт хугацаа 5 жил байна.


4.3 Гэрээний хугацаа дуусмаг гэрээний хоёрдугаар зүйлийн 2 дахь заалтын биелэлтийг Ашигт малтмал, газрын тосны газар болон аж ахуйн нэгжийн төлөөлөгч /эрх бүхий этгээд/ хамтран гэрээг дүгнэж акт үйлдэнэ.


4.4 Гэрээг гурван хувь, Монгол хэл дээр үйлдэх бөгөөд нэг хувийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, нэг хувийг Ашигт малтмал, газрын тосны газар, нэг хувийг ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж тус тус хадгална. Гэрээний хувиуд болон гэрээний хавсралт нь нэгэн адил хүчин төгөлдөр байна. Гэрээ нь нийт 4 хуудас, хавсралт-1 хуудаснаас бүрдэнэ.


4.5 Аж ахуйн нэгж нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Ашигт малтмал, газрын тосны газар нь шүүхэд хандаж болох бөгөөд шүүх ажиллагаатай холбогдон гарах зардлыг аж ахуйн нэгж хариуцан төлнө.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**


**АШИГТ МАЛТМАЛ ГАЗРЫН ТОСНЫ  
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ:**

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН  
ҮТОГ-ч  Ж.БАТМАГНАЙ

УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН  
ҮТОГ-ч  Д.ХАНГАЙ

ГЕОЛОГИ ХАЙГУУЛЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН  
ҮТОГ-ч  Д.АЛТАНХУЯГ


**ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙГ  
ТӨЛӨӨЛЖ:**

“УУЛС ЗААМАР” ХХК-ИЙН ЗАХИРАЛ  
  
..... З.БАТБААТАР


Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо,  
Үйдвэрлэлийн баруун бүс-16101, Москвагийн  
гудамж 98, НЗМС-ийн байр, Утас:70001311,  
Факс:70171310

№ХАЗ- 20/11.110. гэрээ

2016 онд

Улирлууд	Төлбөл зохих /Төгрөг/	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1			
2			
3			
4	34,000,000	34,000,000	2016-12-14 

2017 онд

Улирлууд	Төлбөл зохих /Төгрөг/	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1			
2			
3	139,000,000	139,000,000	2017-07-20 
4			

2018 онд

Улирлууд	Төлбөл зохих /Төгрөг/	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1			
2			
3	139,000,000		
4			

2019 онд

Улирлууд	Төлбөл зохих /Төгрөг/	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1			
2			
3	104,000,000		
4			

2020 онд

Улирлууд	Төлбөл зохих /Төгрөг/	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1			
2			
3	100,950,037.67		
4			